

ИТГЭЛ

Зохиогч: Арлин Пиенграсс
Зураач: Верн Хенкел
Компьютер графикч: Анджо Кросс
Үб айёоайа: Iaddēñēā Īōī
Орчуулсан: Цэрэнгийн Тунгалаг
© 2013 Фэст Байбл Монгол

Бүх эрх хадгалагдана. Олон улсын Зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан. Хуулбарлан зарахыг хориглоно. Энэ номын зөвшөөрөгдсөнөөс бусад аль ч хэсгийг хэвлэгчийн бичгэн зөвшөөрөлгүйгээр олшруулах ба хэвлэхийг хориглоно.

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Зурагны хажуугаар түүх үргэлжлэх үед номыг хажуу тийш нь тавиад текстэд заасан хэсэгт зураг бүрийг үзүүл.

Хичээл №1

ИТГЭЛИЙН ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Арын хавтасны газрын зураг дээр Ур, Харан, Канаан, Газар Дундын Тэнгис, Ефрат мөрөн болон Халдеи байгаа.

Бурханы Үг бол мөнх амийг авчирдаг амьд үр юм. Бид Бурханы Үгийн дүчээр дахин төрж, өсч бойжоод, үйлчлэлд бэлтгэгддэг. Өөрсдийнхөө төлөө Бурханы Үгийг судал хэмээн сурагчдаа дэмж. “Итгэл нь сонсохоос, сонсох нь Бурханы Үгээр ирдэг” гэдгийг сана (Ром 10:17).

Сóáĕāō Áĕáĕēēí ēōēŷĕ;:ä: Эхлэл 12:1-9; Үйлс 7:2-4; Хичээлд дурьдагдсан бүх ишлэлүүд.

Õĕ-ŷŷēēēí ċīdēēāī: Үнэн итгэлийн үр дүн бол Эзэнд дуулгавартай байх гэдгийг харуулах.

Īródīóóāīi ĭŷāŷō , ñōīē ċ;:ēē: Бурхан дуулгавартай байдлыг тушаадаг ба хүндэлдэг.

Īródīóóāīi ĭŷāđŷō , ñōīē ċ;:ēē: Эзэнийг дагах хүсэл.

Īródīóóāīi dēēđ ēstōī ċ;:ēē: Бурханы хүслийг мэдэхийн тулд хайх, тэгээд үйлдэх.

Õĕ-ŷŷēēēí d°ē°āē°ā° (áāāō, Īródīi dŷīāŷāēŷl):

1. Абрамын гэр.
2. Бурханы тушаал (Эхлэл 12:1-3; Үйлс 7:2-3).
3. Абрамын хариу үйлдэл (Эхлэл 11:31; Үйлс 7:4).
4. Ӣргөлийн тахилын ширээ (Эхлэл 12:4-9).

Õŷŷāēēŷō ēōēŷĕ:

Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. (Еврей 11:6)

ÕĒ×ҮҮĒ

Бурхан Адамыг бүтээсэн билээ. Гэвч гэм нүгэл Адамын амьдралыг эвджээ. Мөн Адамын хүүхдүүдийн болон ач хүүхдүүдийнх нь амьдралыг ч эвдэн бусниулжээ. Хүмүүс маш муухай болсон тул Бурхан Өөрийг нь дагасан хэдхэн хүнээс бусад бүх амьд мах бодиудыг устгах ёстой болжээ. Тэр хэдхэн хүн нь Ноа болон түүний гэр бүл байв. Бурхан Ноатай дахин эхлүүлсэн боловч жил өнгөрөх тусам хүмүүс Бурханыг мартаж, өөр өөрсдийн замуудаар явах болов.

Тэднийг залбирахад нь мод ба чулуун бурхад тэднийг сонсч чадах уу? Тийм бурхад тэдний залбиралд хариулж чадах уу? Тэднийг тусламж гуйн хашгирахад нь нар ба сар тэдэнд тусалж чадах уу? Хэзээ ч үгүй! Тэдний шүтэхээс татгалзаад байгаа цорын ганц амьд Бурхан л залбирал гуйлтыг сонсч

үүнд хариулж чадна.

Хүмүүс Бурханыг мартаж, хүчирхэг алдартай болох төлөвлөгөө зохиож эхлэв. Удирдагчид нь шинэ санаагаа дэвшүүлэхийн тулд ард түмнээ дуудан цуглуулжээ. (Эхлэл 11:3-4-ийг үз.)

“Бид тэнгэрт тулам өндөр цамхагтай хот байгуулах болно” хэмээн зарлагч зарлав. “Цамхаг нь асар олон метрийн урттай дугуй хэлбэртэй байх болно. Бид нэрээ мандуулна. Хүн бүр биднийг шагшин гайхаж, биднээс айх болно. Ийм аргаар бид бүх дэлхийн хүмүүсийг захирна” гэв.

“Агуу том санаа байна!” хэмээн бүгд зөвшөөрчээ. “Хэзээ эхлэх вэ?” “Даруйхан эхэлцгээе” гэж тэд хариулцгаав.

Бурхан тэднийг газар дэлхийгээр тарж, өсөн үрж гэж тушаасан билээ. (Эхлэл 9:1-ийг үз.) Гэвч тэд Бурханд дуулгаваргүй хандаж, нэг газар бөөгнөрөөд цамхаг барьж эхлэв.

Бурхан тэдний хийж байгаа бүхнийг дээрээс нь харж “Хүмүүс ер нь Намайг дагах уу? Тэд ер нь Над руу хандан залбирч, тэдний юу хийх ёстойг нь өөрсдөд нь харуулаач гэж Надаас гуйх уу? Би Өөрийгөө тэдэнд Тэнгэр ба дэлхийн захирагч, Бурхан Эзэн гэдгээ харуулна. Одоо тэд бүгд нэг хэлээр ярьж байна. Би тэдэнд өөр өөр хэлүүдийг өгч, тэд бие биеэ ойлгохгүй болно” гэж хэлэв (Эхлэл 11:5-9).

Дараагийн өдөр нь хүмүүсийг ажиллахаар цугларахад ажлын даамал тэдэнд үүрэг өгчээ.

“Тэр юу хэлэв ээ?” гэж ажилчид асуув. “Бид таныг ойлгохгүй байна. Та ямар хэлээр яриад байна вэ?” Тоосго өрж байгаа хүмүүс нь тоосго зөөж байгаа хүмүүсийнхээ хэлийг ойлгосонгүй. Цемент зуурах ус зөөж байгаа хүмүүс нь зуурмаг хийж байгаа хүмүүсээ ойлгосонгүй.

Удирдагчид нь бүгдийг дахин дуудаж цуглуулав. “Бид ингэж самуурч будлиад байвал яаж ажлаа үргэлжлүүлэх юм бэ?” гэж зарлагч асуув. Гэвч цугласан олон бие биеэ ойлголцсонгүй. Эцэст нь тэд зүгээр л буун өгч, хот болон цамхаг барихаа зогсоов!

Ийнхүү Бурхан Өөрийн хүч чадлыг дахин нэг удаа харуулж, Өөрийн төлөвлөсөн ёсоор хүмүүсийг газар дэлхийгээр тараан амьдруулжээ.

Ижил хэлээр ярьж буй хүмүүс нь хамтдаа нэг газар суурьшин, урьдын адил амьдралаа үргэлжлүүлэв. Гэвч харамсалтай нь, тэд Бурханыг хүндлэхээ больжээ. Цамхаг барихыг зогсоосон Нэгэн нь Тэр байсан гэдгийг тэд мэдсэнгүй.

1. АБРАМЫН ГЭР

Эдгээр хүмүүсийн зарим нь Халдеи гэдэг газар

суурьшив. Тэд Ефрат мөрний эрэг дээр нэгэн том хот байгуулж, түүнийгээ Ур гэж нэрлэв. (Баги: Арын хавтасны газрын зураг дээр эдгээр газруудыг зааж үзүүл.) Сайхан амьдрахын тулд маш олон хүмүүс, гэр бүлүүд энэ хотод иржээ. Далайн хөлгүүд зааны яс, мөнгө, зэс авчирч Ур хотынхонд зардаг байв. Урын хүмүүс эдгээр гоёмсог зүйлсийг өөрсдийн үр тариа, жимс, будаагаар сольж авдаг байв. Ийнхүү арилжаа наймаа хөгжжээ.

Голын хөвөө нь үржил шимт билчээр нутагтай тул маш олон тариаланчид, малчид Ур руу нүүжээ. Хүмүүст боловсрол чухал байв. Тэд асар том номын сан байгуулжээ. Тэд үйлдвэрлэлийг хөгжүүлэв. Тэд вааран эдлэл, хөгжмийн зэмсгүүд, алтан мөнгөн хөшөөнүүд болон эрдэнийн чулуун эдлэлүүдийг хийдэг байв.

Ур хотын хүмүүс шашинлаг хүмүүс байв. Үнэндээ хот, сарны бурханд зориулж бүтээсэн үзэсгэлэнтэй, үнэтэй дуганыг дээр нь барьсан хамгийн өндөрлөг газрыг тойрч баригдсан байв. Тахилчид болон эмэгтэй тахилчид энэ хуурамч бурханд өргөл өргөн дуганд үйлчилдэг байв. Хотын болон түүний эргэн тойрны газрын хүмүүс дуганд мөргөхөөр тогтмол ирдэг байв. Онцгой баяр ёслолын өдрүүдэд сар бурхны хөшөөг мөрөн дээрээ үүрсэн эрэгтэйчүүд хотын гудамжаар жагсан алхдаг байв. Дараа нь тэр хөшөөг өндөрт баригдсан дуганы оройд байдаг байранд нь авчирдаг байв.

Абрам гэдэг нэртэй нэгэн залуу эр эцэг Тера, дүү Нахор Харан нарын хамт Урд амьдардаг байв. Абрам болон түүний ах дүүс эцгийнхээ мал сүргийг харж хариулдаг байв. Тэд сургуульд явж уншиж, бичиж сурчээ. Тэд усан онгоцнууд зогсоол дээр ачаагаа буулгаж байхыг хардаг байв. Тэд эцгийнхээ хамт сар бурхны том дуганд очдог байв. (Иошуа 24:2-ыг үз.)

Абрам залуу насандаа Сара гэдэг үзэсгэлэнт эмэгтэйтэй гэрлэжээ. Тэд Урд маш олон найз нөхөдтэй, амьдрал нь өөрсдөд нь тааламжтай сайхан байлаа. Абрам эцэгтэйгээ хамтран ажилласаар баян болжээ. Тэр маш олон мал сүрэгтэй, мөн өөрт нь болон Сарад туслах зарц нартай байв.

Гэвч түүний бүх баялаг, тав тухтай орон гэр болон олон найз нөхөд нь Абрамын зүрх сэтгэлийн гүн дэх хүсэл мөрөөдлийг хангадаггүй байжээ. Бурхан Ур нутагт түүний эргэн тойрон байгаа хуурамч шүтээнүүдээр түүний сэтгэлийг хангуулсангүй.

Библид Абрам болон түүний эцэг хоёрын яриаг тэмдэглээгүй, гэвч иймэрхүү яриа болж байсан болов уу:



Сóдóаа '1

“Аав аа, дуганд байдаг сарны бурханы хөшөө бидэнд тусалж чадна гэж та итгэдэг үү?” гэж Абрам асуув. “Та түүнийг үнэхээр бидэнд сайн ургац, мал сүрэгт маань билчээр хоол өгч байдаг бурхан гэж боддог уу? Алтаар хийсэн бурхан яаж ингэж чадах вэ? Дуганд хөшөө цутгаж хийдэг

хүнийг бид мэднэ. Тэр шүтээн дотор хүч байж чадахгүй” гэж Абрам яриу.

“Гэвч Абрам, хүн бүр тэр бурханд өргөл өргөдөг. Хүн бүр тэр дуганд мөргөдөг. Хэрэв бид дуган руу явахаа боливол тэд биднийг шүүмжлэх болно. Хэрэв бороо орохгүй бол тэд биднийг буруутгана. Тэгэхлээр бид сарны бурханд өргөх өргөлөө зогсоож болохгүй” гэж эцэг нь тайлбарлав.

“Эцэг минь, би тантай хамт дахин сүм рүү явахгүй. Шүтээнүүдэд хүч байхгүй. Тэдэнд амь

байхгүй. Би тэдгээрийг шүтэхээс татгалзаж байна. Харин биднийг бүтээсэн, бидний удирдагч болох амьд Бурхан байх ёстой хэмээн би үнэнээр итгэж байна” гэж Абрам хэлжээ.

2. БУРХАНЫ ТУШААЛ

Эхлэл 12:1-3; Үйлс 7:2-3

Сóдóаа '2



Үнэн ба амьд Бурхан Өөрөө Абрамтай ярих нэгэн өдөр иржээ.

“Абрам, Би чамайг энэ нутаг ба эндхийн хүмүүсийг орхиж явахыг хүсч байна. Би чамайг төрөл төрөгсдөө орхихыг хүсч байна. Би чиний хаашаа явахыг зааж өгнө. Өөрт хамааралтай бүхнээ ав. Мал сүрэг, зарц нараа цуглуулж холын аянд бэлтгэ” гэж Бурхан хэлэв.

“Абрам, чи Намайг дагасандаа харамсахгүй байх болно. Энэ дэлхийн бүх хүмүүс өөрсдийнхөө замыг дагадаг. Тэд хуурамч шүтээнүүдийг шүтдэг. Тэд Миний дуу хоолойг сонсохоос татгалздаг. Би шинэ үндэстнийг бүтээх болно, чи түүний эцэг нь болно. Абрам, Би чамайг ерөөнө. Чиний хийсэн бүхэн чинь амжилттай байх болно. Би чиний нэрийг агуу болгоно. Чи бусдад ерөөл болох болно. Чамаар дамжиж дэлхийн бүх үндэстнүүд ерөөгдөх болно” гэж Тэр хэлжээ.

Бурханы тушаал төгс тодорхой байлаа. Бурханы түүгээр хийлгэхийг хүссэн зүйлийг ойлгоход Абрамд хэцүү биш байлаа.

Бурханы амлалтууд гайхамшигтай байлаа. Гэвч хэрэв Абрам эдгээр амлалтуудад баярлахыг хүсч байвал тэр Бурханы тушаасан зүйлүүдийг хийх ёстой байлаа. Түүний хувьд “Тийм ээ, Бурхан минь, Та амласнаараа намайг ерөөнө гэдэгт би итгэж байна. Та намайг Ураас гарч явахыг хүсч байгаа гэдэгт би итгэж байна” гэж хэлээд орхих нь хангалтгүй юм. Тэр өөрийнхөө амьд Бурханд итгэх итгэл нь бодитой байсан гэдгээ баталж Бурханыг дагах ёстой.

3. АБРАМЫН ХАРИУ ҮЙЛДЭЛ

Эхлэл 11:31; Үйлс 7:4

Сайн нөхрийн хувьд Абрам Бурханы тушаалыг эхнэртээ хэлжээ. “Сара, Бурхан биднийг хааш нь авч явахыг би мэдэхгүй. Харин энэ аян зам чамд хэцүү байх болно гэдгийг би мэдэж байна. Гэвч бид Түүнийг бүрэн дагавал Бурхан биднийг ерөөнө гэсэн. Тэр намайг төрсөн нутаг, төрүүлсэн эцгээ орхин явбал надад өөр нэг газар нутаг өгч намайг агуу үндэстний эцэг болгоно гэж амласан. Тэр бол амьд Бурхан гэдгийг бид мэддэг. Тэр Өөрийн амласнаа хийж чадна, хийх болно” гэж Абрам тайлбарлажээ.

“Гэвч Абрам, бид хүүхэдгүй агал Бурхан яаж чамайг үндэстний эцэг болгох юм бэ?” гэж Сара асуужээ.

“Би мэдэхгүй байна. Бурхан тэгж амласан гэдгийг л би мэдэж байна. Тэр хэлсэнээ хийх болно гэдэгт би итгэж байна” гэж Абрам энгийнээр тайлбарлажээ.

Урт аян замын нүүдэлд бэлтгэх тушаал өгөгдсөний дагуу Абрамын гэр бүлд эрч хүчтэй баяр хөөртэй хөл хөдөлгөөн бий болов.

“Бид хаашаа нүүх гэж байгаа юм бэ?” хэмээн Сарагийн шивэгчин түүний хувцаснуудыг сагсанд нямбайлан эвхэж хийнгээ асуув.

“Хэн ч мэдэхгүй юм шиг байна” гэж түүний туслагч хариулав.

“Эндээс яв гэж ямар бурхан Абрамд хэлсэн юм бол?” гэж эхний зарц асуув.

“Амьд Бурхан Абрамтай ярьсан гэж тэд хэлсэн.

Бидний эзэн дуган дахь шүтээнүүдийг шүтэхээс татгалзсаныг чи мэдэж байгаа. Тэр гэр орондоо ямар ч шүтээн байлгахыг зөвшөөрдөггүй. Бүтээсэн бүтээлүүдээ захирдаг, бүхнийг бүтээсэн цорын ганц амьд Бурхан болох Бурхан байдаг гэж тэр хэлдэг.”

Тэр үед Абрамын дүү Нахор түүнийг хориглохыг оролдов.

“Та яагаад нүүх гэж байгаа юм бэ? Энд бидний мал сүрэгт хангалттай билчээр ус байна. Сараг аваад ийм аялал хийх нь аюултай байх болно. Замд дээрэмчид тааралдана. Тэд таныг алаад Сараг өөрсдөдөө авч магадгүй шүү дээ. Та эндээ үлдэх хэрэгтэй” гэв.

“Нахор, би Бурханыг дагах ёстой. Тэр надтай ярьж, намайг яв гэж тушаасан. Би үлдэж болохгүй. Тэр биднийг харж асарна гэдгийг би мэдэж байна” гэж Абрам хариулжээ.

“Тэгвэл, хаашаа явах юм бэ?” гэж Нахор мэдэхийг хүсэн асуув.

“Үүнд би хариулж мэдэхгүй. Яг хаашаа явахыг Бурхан надад хэлээгүй байгаа. Би зөвхөн явж эхлэх ёстой гэдгийг л мэдэж байна. Тэр намайг өдөр бүр хөтлөн дагуулна гэдэгт би итгэж байна” гэж Абрам эрс шийдэмгий хариулжээ.

“Хүссэнээ хий дээ. Гэвч би таныг бусдын адил тэнэг юм хийж байна гэж бодож байна” хэмээн Нахор хэлэв.

“Бурхан ярьсан. Бурхан амласан. Бурхан биднийг харж хандана” гэж Абрам итгэлтэйгээр яриу. Нахорын хэлдэг зөв ч юм болов уу хэмээн тэр гайхсан ч байж магад.

Гэвч итгэлээр тэр явах бэлтгэлээ үргэлжлүүлсээр байв. (Еврей 11:8-ыг үз.)



Зодай '3

Урт аян замдаа гарах өдөр иржээ. Баяртай гэж хэлэх хэзээ ч амар байдаггүй, тэр үед маш их нулимс гардаг.

“Өө, Сара, Бид чамайг санана! Бид дахин уулзалдах болов уу?” хэмээн түүний хамаатнууд, найзууд асуув.

“Би мэдэхгүй” гэж Сара сайхан нүднээсээ нулимс унагаан хариулав. “Би зөвхөн миний нөхөр Бурханыг дагах ёстой гэдгийг л мэдэж байна. Мөн Бурханы дагуулах газар руу би түүнтэй хамт явж байгаадаа баяртай байна” хэмээн тэр хэлэв.

Сара нар, салхи, шорооноос нүүрээ хамгаалахын тулд толгойгоо алчуураар ороогоод тэмээн дээрээ мордов. Тэгээд тэр гар даллан салах ёс хийгээд мал сүрэг болон зарц нарын асар том нүүдлийг удирдан яваа Абрам болон эцэг Терагийн араас дагаж Халдеин Ураас хөдөллөө.

“Ач дүү Лот минь надтай хамт явж байгаа нь сайн байна. Энэ их мал сүргийг харж хандахад тэр надад их тус болно” гэж Абрам хэлж байв. (Бурхан түүнд газар нутаг болон төрөл төрөгсдөө орхиод нүү гэж хэлснийг Абрам мартчихсан уу? Үгүй, харин түүний аав болон ач дүү нь түүнтэй хамт явжээ. Эхлэл 11:31-32; Үйлс 7:2-4-ийг үз. Тэр бүрэн дуулгавартай байсан уу?)

Нүүдэлчид орой бүр майхнаа босгож, малаа тэжээж, гал түлж, цай хоолоо хийж иддэг байв. Өглөө бүр майхнаа буулган ачаалж аяллаа үргэлжлүүлж байлаа.

Олон өдөр, сар явжээ. Тэд ядарч цуцав. Сара үе үе “Абрам, Бурхан таныг удирдаж байгаа гэдэгт та итгэлтэй байна уу?” гэж асууж байв.

“Тийм ээ, би Түүнийг байдаг гэдгийг мэднэ.

Биднийг ерөөнө гэж Тэр амласан. Бид Түүний тушаалыг дагаж байна. Тэр бидний сэтгэлийг гонсойлгохгүй. Тэр биднийг бүтэлгүйтүүлэхгүй” гэж Абрам урамтай хэлж байлаа. (Еврей 11:8-ыг үз.)

Абрам амьд бөгөөд үнэн, Тэнгэрийн Бурханыг хайрлан биширч байлаа. Гэвч түүний настай эцэг тийм биш байв. Тэр хуурамч, хиймэл бурхдыг шүтэж байв. (Иошуа 24:2-ыг үз.) Ийнхүү тэд 965 орчим км аялсны дараа Харан гэдэг хотод иржээ. (Газрын зураг дээр харуул.) Бурхан тэдэнд тэнд аяллаа зогсоо гэж хэлээгүй. Гэвч Абрамын эцэг амьд Бурханыг сонирхохгүй байв. Тиймээс тэд бүгд Харанд суурьшжээ. Хэдэн жилийн дараа хөгшин эцэг нь нас барав. (Эхлэл 11:32-ыг үз.) Одоо, эцэст нь Абрам эцгээсээ салав. Бурхан дахиад түүнтэй ярьжээ. Абрам дахин өөрт хамааралтай бүхнээ аваад, эхнэр Сара болон ач дүүгийнхээ хамт цааш нүүжээ.

4. МӨРГӨЛИЙН ТАХИЛЫН ШИРЭЭ

Эхлэл 12:4-9

Нэг, эсвэл хэдэн сарын дараа тэд Канаанд ирсэн байх. Тэнд Бурхан Абрамд үзэгдэж “Абрам, энэ бол чиний үр хүүхдүүдэд Миний өгөх гэж байгаа газар билээ!” гэж хэлэв.

Тэр өдөр ямар их баяр хөөртэй өдөр байсан бол! Хэрэв Абрам Бурханыг дагахаасаа татгалзсан бол тэр энэ бүхнийг алдах байлаа. Бурхан өөрийг нь удирдсан бөгөөд Тэр амласан зүйлээ хийх гэж байгаа гэдгээ түүнд дахин итгүүлжээ.

Бурханы үзэгдсэн тэр газар Абрам чулуугаар тахилын ширээ өрөв. Тэр мал алж, тэдгээрийг тахилын ширээн дээр Бурханд тахил болгон өргөжээ.

Содай '4



Абрам, түүний эхнэр Сара, ач дүү Лот болон зарц нар нь тахилын ширээг тойрцгоов (Эхлэл 12:7). Тэгээд Абрам Эзэнд мөргөж, “Та биднийг энэ газар хүртэл удирдаж, аюулгүй авчирсанд баярлалаа, Бурхан минь! Биднийг ерөөсөнд талархаж байна. Та биднийг өдөр бүр хөтлөн дагуулах учир Танд талархаж байна” гэж хэлэв.

Өөрийг нь дагадаг хүнийг Бурхан хэзээ ч бүтэлгүй болгодоггүй. Тэр Сургаалт үгс 3:5, 6-д Эзэнд найд, өөрсдийн оюун ухаанд бүү түшиглэ гэж бидэнд тушаасан билээ. Бид голдуу юу хийхийгээ мэддэггүй. Гэвч Бурхан бидэнд хэрэв бид Түүн рүү харж, Түүнийг сонсвол Тэр бидний замыг чиглүүлэх болно гэж хэлдэг.

Абрам Бурханд итгэсэн учир Бурхан түүнийг зөвт хэмээн тунхаглав (Ром 4:3). Хэрэв бид Түүний Хүү Эзэн Есүс Христийг загалмай дээр бидний гэм нүглийн төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэвэл биднийг ч бас Тэр зөвт хэмээн тунхагладаг (Ром 4:5).

Бурханд Абрамд зориулсан төлөвлөгөө байсны адил бидний хүн нэг бүрийн амьдралд зориулсан төлөвлөгөө Түүнд байдаг. Чи хэрхэн хариулах вэ? Чи Түүнд “Эзэн минь, би энд байна. Намайг ашиглаач” гэж хэлэх үү? Эсвэл “Би өөрийнхөө замаар явах болно. Надад бүү саад бол” гэж хэлэх үү?

Эзэн бидэнд “Тэр биднийг хэзээ ч орхихгүй, хэзээ ч хаяхгүй” гэж амладаг (Еврей 13:5). Түүнийг дагаж байгаа бид “Эзэн бол миний туслагч. Би юунаас айх юм бэ? Хүн намайг яах юм бэ?” гэж зоригтойгоор хэлж чадна (Еврей 13:6).

Нэгэн өдөр Бурхан чамайг пастор, миссионер, эсвэл багш байхыг хүсч магад. Гэвч яг одоо Эзэн чамайг Өөрийнх нь гэр бүлд төрөөсэй гэж хүсдэг.

Тэр чиний нүглүүдийг уучлахыг хүсч байгаа. Яг одоо Тэр чамайг Өөрийг нь дагаасай гэж хүсч байгаа. Яг одоо Тэр бас чамайг найзууддаа Өөрийг нь тэдний гэмийн төлөө үхсэн гэдгийг хэлээсэй гэж хүсч байгаа. Тэр чамайг эргэн тойрныхоо хүмүүст

эелдэг, хайраар хандаасай гэж хүсч байгаа.

Бурхан Абрамын амьдралыг чиглүүлэхийг хүсч байсныхаа адилаар чиний амьдралыг бас чиглүүлэхийг хүсч байгаа. Чи үүнийг Түүнд зөвшөөрөх үү?

Хичээл №2 ИТГЭЛИЙН ДОРОЙ БАЙДАЛ

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Багш хүн анхнаасаа багш болж төрдөггүй, харин бэлтгэгддэг. Сайн багш өөрийгөө сургах хүсэлтэй байх ёстой. Ариун Сүнсэнд улам илүү хамааралтай байх тусам, илүү үр дүнтэй ашиглагдах тусам та Бурханы Үгийг заах болно. Та үнэхээр Бурханд итгэж, Түүнийг Үгээр нь хүлээн авдаг уу? Та зөвхөн Түүнд өөрөө найдаж байж тэднийг Түүнд бүрэн дүүрэн итгэлтэй болоход нь дэмжин урамшуулж чадна.

Сóäëäò Áäáëëéí èøëýë; ;ä: Эхлэл 12:10-20; 20:1-14; 21:1-8; 16:1-17:8, 15-27; 18:1-15.

Õè-ýýëëéí çíðëëýí: Хэдийгээр бид бүдэрдэг боловч Бурхан итгэмжтэйгээр тэсэн хүлээдэг гэдгийг харуулах.

Íðóðíóááüí ÿüýð , ñòíë ç;éë: Бид унах хэрэггүй юм.

Íðóðíóááüí ÿüýð , ñòíë ç;éë: Бурхан биднийг Өөрт нь итгэлтэй байлгаж чаддаг.

Íðóðíóááüí ðëëð ёстой ç;éë: Эзэнд хамааралтай байж, Түүнийг дагах.

Õè-ýýëëéí ð°è°äë°ä° (áäáø, íðóðíü ðýíäýäëýл):

1. Хангамж болон аюулгүй байдлын төлөө Бурханд найдаж чадаагүй нь (Эхлэл 12:10-20).
2. Бурханы амлалтанд итгээгүй нь (Эхлэл 15:1-6; 16:1-16).
3. Бурханы амар тайвантай байж чадаагүй нь.
4. Абрамын сул дорой байдал ба Бурханы итгэмжтэй байдал (Эхлэл 17:1-8, 15-27; 18:1-15; 21:1-8).

Õýýäëýð èøëýë:

Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. (Еврей 11:6)

ÕÈ×ÝÝÈ

Абрам Сара хоёр болон тэдэнтэй хамт шинэ газар ирсэн олон зарц нар суурьшиж, өдөр дутмын хэвийн ажилдаа оров. Одоо тэд яг Бурханы тэднийг удирдан авчирсан газар нутагт байлаа. Хоньчид хонь ямаан сүргээ хариулж, бусад малчид нь үхэр малаа харж хандав. Эмэгтэйчүүд нь хоол унд хийн, хувцас хунараа угаан завгүй ажиллацаав.

1. ХАНГАМЖ БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БУРХАНД НАЙДАЖ ЧАДААГҮЙ НЬ Эхлэл 12:10-20

Өдрөөс өдөрт нар хурцаар шарж байлаа. Бороо оролгүй олон хоног сар өнгөрсөөр байв. Нэгэн орой хоньчид майхандаа ирээд Абрамтай ярилцав. “Эзэн минь ээ, өдрөөс өдөрт мал сүрэг маань идэх өвсгүй болж байна. Бид билчээр хайн улам хол явж байгаа боловч газар хуурай байна. Бороо хурдан орохгүй л бол мал сүрэг маань харангадаж үхэх нь” гэж тэд хэлэв.

“Маргааш бороо орж магад” гэж Абрам итгэлтэйгээр хэлэв.

Гэвч тэр өдөр нь нар урьдын адил хурцаар шарж газрыг улам хатааж, үлдсэн жаахан өвсийг нь шатааж байлаа.

“Манай эцэцэрлэг хатчихлаа. Бид хаашаа явж идэх юм олж ирэх вэ?” гэж Абрамын зарц нар асуув.

Зарц нарын зарим нь тавгүйтэж, үглэж эхлэв: “Бид яах гэж энд ирсэн юм бэ? Бид үргэлж элбэг дэлбэг хоол хүнсстэй байдаг Урдаа л байж байх байсан юм.”

Гэвч Абрам, түүний эхнэр болон зарц нарыг хэн энд авчирсан билээ? (Бурхан.) Бурхан одоо тэднийг харж асран хэрэгцээт зүйлсээр нь хангана гэж та нар бодож байна уу? (Тийм ээ, бороо илгээдэг Нэгэн нь Тэр бөгөөд Тэр бидний бүх хэрэгцээг хангах чадвартай.) (Филиппой 4:19-ийг үз.)

Абрам тахилын ширээ өрж, хайр халамжийнх нь төлөө Бурханд талархах ёстой байсан боловч тэр нүүхээр төлөвлөжээ. Бурхан өөрийг нь хөтлөн авчирсан тэр газраас явна гэдэг нь ямар их алдаа вэ!

Абрам зарц нартаа тушаал өгч “Майхнуудаа буулгаж нүүхэд бэлтгэ. Өөрсдийн эзэмшдэг бүхнээ тэмээ малд ачаал. Замын хүнсээ бэлд. Мал сүргүүдээ нийлүүлж туугаад бид Канаанаас явна. Бид урагшаа, Египет рүү явна. Энд байгаад байвал бид үхэх нь. Бороо орохоор бид энд буцаж ирнэ” гэж хэлэв.

Бурхан үүнд ямар их гашуудсан бол! “Өө, Абрам, хэрэв чи Миний чамайг авчирсан энэ газарт үлдсэн бол Би чамайг харж асарч чадна шүү дээ. Нүүхээсээ өмнө Надад залбираач.”

Гэвч Абрам өөрийнхөө хамгийн сайн гэж бодсоноо хийжээ. Тэр итгэлээр биш, хараагаар алхав.

Зураг №5



Египетийн хилд дөхөж ирээд Абрамын сэтгэл зовов. Тэр Сарад итгэн, “Хайрт минь, чи бол үзэсгэлэнтэй эмэгтэй. Египетийн эрчүүд чамайг хараад намайг алж, чамайг эхнэрээ болгож авна. Нэгэнт чи миний дүү учир тэдэнд чи өөрийгөө миний дүү гэж хэлээч. Тэгвэл тэд намайг алахгүй” гэж хэлэв. (Эхлэл 20:12-13-ыг үз.)

Абрамын өөрийгөө хамгаалах гэж хэрхэн арга мэх зохион төлөвлөж байгааг Бурхан хараад ямар сэтгэгдэлтэй байгаа бол гэж та нар бодож байна вэ?

Бурхан Абрам Сара нарыг Ураас Канаан хүртэлхи бүх замд хэрхэн хамгаалж байсныг Абрам мартжээ. Бурхан өөрийг нь ерөөж, олон үндэстний эцэг болгоно гэж амласныг тэр мартжээ. Бурханд найдахын оронд тэр худал хэлэхээр төлөвлөв.

Яг Абрамын айж байснаар Египетийн эрчүүд Сараг үзэсгэлэнтэй хэмээн боджээ. Тэд энэ тухай хаандаа айлтгав. Түүнийг Абрамын дүү гэж бодсон хаан Абрамд мал болон зарц нарыг өгч, оронд нь Сараг авчээ.

“Өө, Абрам, би таныг орхиод энэ хаантай амьдрахаар явах ёстой гэж үү? Би дахин таныг хэзээ

ч харахгүй юу?” гэж буйёуяа Сара мэгшин уйлав.

“Хайрт минь, битгий санаа зов. Канаан нутаг дахь ган гачиг дуусахаар бид хамтдаа буцах болно” гэж Абрам хэлэв. Сара хааны ордон руу хүргэгдэв.

Абрам Сара хоёр Канааныг орхиж явсан нь Бурханы таалалд нийцээгүй билээ. Тэр хоёрын худал хэлсэн нь ч Бурханд таалагдаагүй. Тэр түүнд “Абрам, чи нэгэнт энэ Египетийг Миний чамд сонгож өгсөн Канаанаас илүү дээр гэж үзсэн учир энд үүрд үлд дээ. Би өөр хэн нэгнийг ерөөе” гэж хэлж болох байсан.

Абрамд зохих зүйл нь энэ байв. Гэвч Бурхан бидэнд бидний хүртвэл зохих зүйлийн дагуу ханддаггүй. (Дуулал 103:10-11-ийг үз.)

Бурхан тэднийг хайрласаар байв. Тиймээс Тэр тайлбарлахын аргагүй замаар хаанд Сара бол Абрамын дүү биш, харин эхнэр нь юм гэдгийг хэлэв.

Хаан Абрамыг ордондоо дуудаж, “Та юунд бидэнд худал хэлэв? Та яагаад Сараг өөрийнхөө дүү гэж хэлсэн бэ? Түүнийг аваад одоо манай улсаас яв!” гэж хэлэв.

Абрам Сара хоёр дахин хамтдаа болсонд ямар их талархсан бол! Хэрэв тэд зөвхөн Бурханд найдсан л бол хэзээ ч ингэж салахгүй байх байсан.

Сара “Өө, Канаан нутаг руугаа очсон нь дээр гэж санагдаж байна!” хэмээн уулга алдан хэлэв.

“Намайг Бурханд найдаагүйд уучлаарай, Сара. Чамайг маш их зовоосонд уучлаарай. Канаанд очингуутаа би биднийг хамгаалж, бидний төлөө сонгосон газартаа хөтлөн аваачсаных нь төлөө тахилын ширээ өрж Бурханд талархах болно” гэж Абрам хэлэв.

Ингээд Абрам яг үүнийгээ хийсэн билээ. (Эхлэл 13:4-ийг үз.)

2. БУРХАНЫ АМЛАЛТАНД ИТГЭЭГҮЙ НЬ

Эхлэл 15:1-6; 16:1-16

Абрам Бурханы амлалтыг хэзээ ч мартаагүй гэж бид төсөөлж магад. Мэдээж, тэр Бурханаар удирдуулахын тулд Түүнээс асуухаа хэзээ ч мартаагүй. Гэвч Абрам бидэнтэй л адил байв. Тэр дахиад Бурханы амлалтыг мартаж, өөрийн төлөвлөгөөгөө эхэлжээ.

Бурхан Абрамыг төрсөн нутгаа орхиод яв хэмээн дуудахдаа түүнийг агуу үндэстний эцэг болгоно гэж амласан билээ. Гэвч тэднийг Канаанд ирснээс хойш арван жил өнгөрөв. Абрам Сара хоёр хөгширчээ. Гэвч тэд нэг ч хүүхэдгүй байлаа.



Зураг №6

Нэгэн шөнө Абрам Бурхан яаж амлалтаа биелүүлэх юм бол хэмээн гайхаж байжээ. Бурхан түүнийг гадагш дуудаад “Абрам, тэнгэрийн оддыг хар, тэгээд тоол. Хичнээн байна вэ?” гэв.

“Өө Бурхан минь, би хэрхэн тоолж чадах билээ? Дэндүү олон шүү дээ” гэж Абрам тайлбарлав.

Бурхан “Абрам, чиний үр удам тоолохын аргагүй олон болох болно” гэж амлажээ.

“Энэ нь яаж бүтэхийг би ойлгохгүй байна. Гэвч Бурхан минь, би Таны хэлсэнд итгэж байна. Таныг амласнаа биелүүлнэ гэдэгт би итгэж байна” гэж Абрам хариулав.

“Чи Надад итгэсэн учир, Абрам, чи Надтай зөв байр сууринд байна” гэж Бурхан хэлэв. Бурхан түүнийг зөвт гэж хэлсэн нь Абрам Бурханд итгэсэн учраас юм. (Эхлэл 15:6-г үз.)

Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам Сара улам тэвчээргүй болж байв. Тэр, Бурхан үнэхээр түүнд

хүүхэд өгөх болов уу хэмээн эргэлзэв. Нэгэн өдөр тэр Абрамд нэг санаа хэлэхээр ирэв. Урын ёс заншлыг дагаж тэр “Абрам, Бурхан бидэнд хүүхэд өгөхийг хүлээсээр, хүлээсээр удлаа. Би Түүнийг бидэнд хүүхэд өгнө гэдэгт итгэхгүй байна. Тиймээс та миний шивэгчин Хагарыг ав. Бурхан түүгээр дамжуулж бидэнд хүү өгч магад” гэж хэлжээ.

Гэвч Абрам Сара хоёр бусдаас өөр байв. Тэд амьд Бурханыг дагаж байв. Бурхан тэднийг Урын хүмүүсийн үйлддэгийг дагаасай гэж хүсээгүй. Харин Тэр тэднийг Өөрт нь найдаасай гэж хүсч байв.

Абрам дахин, ийм чухал шийдвэр гаргахынхаа өмнө тахилын ширээ өрж, Бурханд залбирахаа мартжээ. Харин тэр Сарагийн зөвлөлгөөг сонсов. “Сара, чиний зөв байж болох юм. Бурхан Хагарын тусламжтайгаар биднийг хүүтэй болгохыг хүссэн байж магад” гэж тэр хэлэв.

Гэвч хэрэв Бурхан Абрамаар ийм зүйл хийлгэхийг хүссэн бол Тэр түүнд хэлэх байсан! Абрам дахин Бурханаас асуулгүйгээр өөрийн төлөвлөснөөр үйлдэв. Хэдэн сарын дараа Абрамын гэрт Ишмаел гэдэг хүү Хагараас төржээ. Гэвч энэ бол Бурханы Абрам Сара хоёрт амласан хүү биш байлаа.

3. БУРХАНЫ АМАР ТАЙВАНТАЙ БАЙЖ ЧАДААГҮЙ НЬ



Зураг №7

Бурханд дуулгаваргүй байх нь баяр хөөрийн оронд харуусал авчирдаг гэдгийг Абрам даруй ойлгожээ. Бяцхан хүү Ишмаэлыг хараад Сара гунигтай байв. Энэ түүний хүүхэд биш байлаа. Тэр Ишмаэлын эх Хагарт атаархаж, түүнд найрсаг бус хандав.

Сара түүнд ширүүн, тэвчээргүй хандсанаас болж Хагар ч баяр баясалгүй байв. Энэ бүгдээс болж Абрам гунигтай байх болов. Аз жаргалтай хүн нэг ч байхгүй байлаа.

Бурхан ч Абрамын үйлдлүүдэд сэтгэл хангалуун биш байв. Бурхан түүнд Сарагаар дамжиж хүү төрнө гэж амласан байв. Бурхан тэр хүүг Абрамд хэдийд өгөхөө хэлээгүй байв. Гэвч Бурхан Өөрийн амлалтуудаа үргэлж сахин биелүүлдэг. Бурхан Абрамыг өөрийн төлөвлөгөөгөөр үйлдэхийн оронд Түүнд найдаж, Түүнийг тэвчээртэйгээр хүлээхийг хүсч байв. Абрам Сара хоёрын тэвчээргүй байдал зөвхөн сэтгэлийн зовиурыг авчирчээ.

4. АБРАМЫН СУЛ ДОРОЙ БАЙДАЛ БА БУРХАНЫ ИТГЭМЖТЭЙ БАЙДАЛ

Эхлэл 17:1-8, 15-27; 18:1-15; 21:1-8

Арван гурван жил өнгөрөхөд Абрам Бурханы дуу хоолойг сонссонгүй. Гэвч Бурхан Абрам Сара хоёрыг хайрласаар байв. Хэдийгээр тэд заримдаа юу хийх талаар Бурханаас асуухаа мартаад буруу шийдвэрүүд гаргадаг ч Бурханыг дагахыг үнэхээр хүсдэг байсныг Тэр мэддэг.

Абрамыг 99 настай, Сараг 89 настай байхад Бурхан дахин Абрамтай ярьжээ.

“Абрам, Би чиний нэрийг өөрчлөх гэж байна. Одооноос эхлээд чамайг Абрахам буюу олон үндэстний эцэг гэж дуудна. Абрахам, Би чамайг олон үндэстний эцэг болгоно. Би бас ирэх жилийн өдийд Сара та хоёрт хүү өгнө” гэж хэлэв.

“Өө Бурхан минь, энэ чинь боломжгүй. Би зуун настай, Сара ерэн настай байх болно. Ийм хөгшин хүмүүс хүүхэдтэй болж чадахгүй!” гэж Абрам хэлэв. “Энэ үнэн, Абрам. Чам шиг хөгшин хүмүүс хүүхэдтэй болж чадахгүй. Гэвч Би чамд хүү өгнө.

Би бол Төгс Хүчит Бурхан БИ БАЙДАГ тул Би боломжгүй зүйлийг ч хийж чадна. Надад юу ч дэндүү хэцүү биш билээ!” гэж Бурхан хариулав.

Ямар гайхамшигтай амлалт вэ? Тэнгэрийн амьд Бурхан боломжгүй зүйлийг ч хийж чадна!



Зодай 18

Яг Бурханы амласан ёсоор нэг жилийн дараа Абрам Сара хоёрт бяцхан хүү Исаак мэндэлжээ. Тэгэхэд, Бурхан Абрамд хүү өгнө гэж амласнаас хойш хорин таван жил өнгөрсөн байжээ. (Эхлэл 12:2-4-ийг үз.) Эдгээр он жилүүдэд Абрам Сара хоёр

Бурханд үргэлж итгэмжтэй байсангүй. Гэвч Бурхан Абрам Сара хоёрт итгэмжтэй байжээ.

Исаакийн өсч бойжиж байгааг харахад тэдний гэрт ямар их баяр хөөр байсан бол! Өөрийн амлалтаа сахин биелүүлсэнд тэд Бурханд ямар их талархсан бол! Мөн тэдний дуулгаваргүй байдлыг нь уучилсанд тэд Бурханд үнэхээр талархав. Хэзээ ч өөрчлөгддөггүй Бурханы хайранд тэд хичнээн их талархсан бол! Харин тэд заримдаа Бурханы хүслийг үйлдэж, заримдаа өөрсдийнхөө хүссэнийг үйлдэж, маш их хувирамтгай байв.

Абрам Сара хоёрыг хайрлаж байсан Бурхан

биднийг бас хайрладаг. Тэр бидний амьдралыг чиглүүлэхийг хүсдэг. Бурхан биднийг ерөөхийг хүсдэг. Бид голдуу Абрам Сара хоёрын адил аашилдаг. Шийдвэр гаргах ёстой үедээ бид Бурханд залбирдаггүй. Бид Түүний Үгийг уншдаггүй. Бид Түүний амлалтуудад итгэдэггүй. Бид залбиралдаа тэр даруйд нь хариу авахгүй бол тэвчдэггүй. Ингээд бид хүссэн хариултаа өөрсдөөсөө аваад өөрсдийнхөө төлөвлөгөөний дагуу ажилладаг.

Гэвч Бурхан биднийг хайрласаар байдаг. Тэр бидэнд тэвчээртэй ханддаг. (Дуулал 103:8, 10, 11-ийг үз.) Биднийг Түүнээс өршөөл гуйхад Тэр бидний дуулгаваргүй байдлыг уучилсаар байдаг (1 Иохан 1:9). Тэр бидний нүглүүдийг уучлаад зогсохгүй, бүр мартдаг.

Хэрэв бид Есүс Христ бол Бурханы Хүү бөгөөд бидний нүглүүдийн төлөө загалмай дээр үхсэн гэдэгт итгэвэл Бурхан бидэнд мөнх амийг өгнө гэж амласан билээ. (Иохан 3:16-г үз.) Бурхан Өөрийн амлалтаа биелүүлэх болно. (Тит 1:2-ыг үз.)

Бурхан бас тэдний гэм нүглүүдийн төлөө Өөрийнх нь Хүүг загалмай дээр үхсэн гэдэгт итгэдэггүй хүмүүсийг галт нуурт мөнхөд шийтгэнэ гэж амладаг (Иохан 3:36; Ром 6:23; Илчлэлт 20:13-15). Бурхан энэ амлалтаа бас сахин биелүүлэх болно. Аль амлалтыг нь чи өөрийнхөө төлөө биелэгдээсэй гэж хүсч байна вэ?

Хичээл №3 ИТГЭЛИЙН ШАЛГУУР

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Та оюутнуудынхаа сүнслэг хэрэгцээнүүдийг сайн мэддэг үү? Эдгээр хэрэгцээнүүдийн төлөө хэрхэн үйлчилж хичээлээ хэрхэн тохируулж бэлтгэхээ тодорхойл. Хичээлээ бэлдэж байхдаа залбиралд цаг зарцуул, ингэснээр Эзэн тэднийг таны хичээлтэй холбож өгнө.

Сбәәәо Аәәәәи өөөүө; ç:ä: Эхлэл 13; 18; 19; 22

Өө-үүөөи çидддд: Тэр биднийг Өөрт нь улам илүү найдаж, Өөрөөс нь бүрэн хамааралтай байхын тулд Өөрийнхөө дотор бидний итгэлийг шалгадаг гэдгийг харуулах.

İрöööбббйй йүүүө, нддд ç:ëë: Шалгуур нь Бурханаас зорилготой ирдэг.

İрöööбббйй йүүүө, нддд ç:ëë: Бурхан би-нийг хүчирхэгжүүлэхийн тулд сорьдог гэдэгт итгэх.

İрöööбббйй дддд ёстой ç:ëë: Бид хэдийгээр өөрсдийн нөхцөл байдлуудыг бүгдийг ойлгодоггүй ч Бурханд найдах.

Өө-үүөөи ддддäää (äää, irööüü öyüüäyü):

1. Абрахамын хүслийг шалгав (Эхлэл 13).
2. Абрахамын үйлсийг шалгав (Эхлэл 18:1-33; 19:1-26).
3. Абрахамын хайрыг шалгав (Эхлэл 22:1-14).
4. Шалгуур бол Бурханы зорилгын нэг хэсэг юм (1 Коринт 10:13).

Öүүүөүө өөөүө:

Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. (Еврей 11:6)

ХИЧЭЭЛ

Бидний бүх юм сайн болоход бид голдуу Бурханыг мартдаг. Бид Түүнд талархахаа мартдаг; Түүнд залбирахаа мартдаг. Заримдаа Тэр бидэнд хэрэгтэй гэдгийг мартдаг. Тийнхүү Өөрт нь хамааралтай байх талаар бидэнд сургахын тулд Тэр

бидний амьдралд асуудал болон бэрхшээлүүдийг илгээдэг. Тэр биднийг Өөрт нь алдар ба магтаалыг авчирдаг хүчирхэг Христчин болгохыг хүсдэг. Тэр биднийг сорих үед бид Түүнээс тусламж хүсэн Түүн рүү харвал бид илүү хүчтэй болно гэдгийг Тэр мэддэг. (Иаков 1:2-4-ийг үз.)

Бурхан Абрахамын амьдралд олон шалгууруудыг авчирчээ. Тэр түүнийг Бурханы хэрэгтэй хүн болгохыг хүсчээ. Эдгээр шалгуурууд Бурханы Үгэнд бичигдсэн тул бидний амьдралд хүнд хэцүү зүйл ирэхэд бид юу хийж болох талаар сурах юм. (1 Коринт 10:11-ийг үз.)

1. АБРАХАМЫН ХУСЛИЙГ ШАЛГАВ

Эхлэл 13

Абрахам Лот нар Египетээс буцаж ирсэн бөгөөд тэд хоёулаа баян хүмүүс байв. (Эхлэл 13:2, 5-ыг үз.) Тэд тус тусдаа олон зарц нартай, олон майхнуудтай, олон мал сүрэгтэй, их алттай байв. Харамсалтай нь Абрахамын болон Лотын малчид малынхаа сайн билчээр нуггийг булаалдаж, маргалдан тулалджээ.

“Энд бид эхэлж ирсэн. Та нар өөр нутаг билчээр хай” гэж Лотын малчид хэлэв.

“Манай эзэн чамаас илүү агуу. Та нар өөр билчээр хай. Бид Абрахамын мал сүрэгт хамгийн сайн билчээрийг сонгох ёстой” гэж Абрахамын зарц нар хариулав.

“Замаас зайлцгаа. Бид Абрахамын малыг услая!”

“Ээлжээ хүлээ! Бидний мал одоо ууж байна.”

Ийнхүү тэд өдрөөс өдөрт маргалдаж байв.



Зураг №9

Абрахам үүнийг сонсоод Лотыг дуудав.

“Лот, бид өөрсдийн малчдын хоорондох маргааныг зогсоох ёстой. Чи миний ач дүү. Би чамд хайртай. Бидний хооронд ямар нэг үл ойлголцол байхыг би хүсэхгүй байна. Тэгээд ч бид амьд Бурханд үйлчилдэг. Тулалдах нь Бурханыг

хүндэтгэж буй хэрэг биш. Канаан дахь бидний хөрш улсууд биднийг Тэнгэрийн Бурханд итгэдгийг мэднэ. Хэрэв тэд манай малчдыг маргалдан тулалдаж байхыг харвал, тэд үнэн Бурханыг өөрсдийнх нь шүтдэг бурхдаас илүү дээргүй юм байна гэж бодох болно” гэж хэлэв.

“Лот, эргэн тойрны бүх газруудыг хар. Бидэнд хангалттай их газар нутаг байна. Хаана нь амьдармаар байна, түүнийгээ сонго. Чиний сонгоогүй газрыг би авъя” гэж Абрахам үргэлжлүүлэн хэлжээ.

Абрахам ахмад нь бөгөөд гэр бүлийн удирдагч байв. Лот түүгээр эхэлж сонгуулж болох байв. Гэвч Лот хялбар амьдралыг хүсчээ. Тэр зөвхөн өөрийнхөө тухай бодож, хамгийн сайныг хүсчээ. Тэр эргэн тойрны бүх газрыг харж, нэгэнт би эхэлж сонгох учир хамгийн сайныг нь сонгоно гэж бодов. Иордан голын дагуу элбэг устай юм. Билчээр нь илүү баялаг, илүү ногоон харагдаж байна. Содом, Гоморра гэдэг хоёр том хот тэнд байна. Тэнд амьдрахад тухтай, хялбар байх болно гэж тэр бодов.

“Авга ах минь, Би зүүн тийш явъя гэж бодож байна. Миний гэр бүл болон зарц нар тэр хотын ойролцоо буух болно. Надад сонголт хийхийг зөвшөөрсөнд баярлалаа. Таны хувьд бүх юм сайн байна хэмээн найдаж байна” гэж Лот хэлэв. Лот бүхэл гэр орноо аваад сонгосон газар руугаа нүүв. Тэр хаашаа явах ёстойгоо Бурханаас асуусангүй. Тэр сонголтоо өөрөө хийжээ.

Лотын нүүхийг хараад Абрахам ганцаардав. Тэр өөрт нь хоёр дахь сайн нь оногдлоо гэж бодсон уу? Библид энэ тухай хэлээгүй. Хэрэв тэр тэгж бодсон бол Бурханы түүнд хэлсэн үгнээс болж энэ нь удалгүй өөр болсон байх ёстой.

“Абрахам, хойш урагш, баруун зүүн тийш хараа чинь хүрэх бүх газрыг хар. Би чамд болон чиний үр хүүхдүүдэд чиний харж байгаа бүх газрыг өгнө. Би чамд тоолохын аргагүй маш олон үр хүүхдүүдийг өгөх болно. Абрахам, Би чамайг энэ газар нутгаар баярлан цэнгээсэй гэж хүсч байна. Явж, энэ газар нутгийг үз. Энэ бол чинийх!” гэж Төгс Хүчит Бурхан амлажээ.

Абрахам тахилын ширээ өрж, Бурханд мөргөв.

“Эзэн минь, намайг сонгож авсанд Тандаа талархаж байна. Таны сонголт хамгийн сайн билээ. Та амласан бүхнээ надад өгөх болно гэдэгт би итгэж байна” гэж тэр залбирав. Абрахам Бурханы өөрт нь сонгосон юуг ч үнэнээр хүсч байлаа.

2. АБРАХАМЫН ҮЙЛСИЙГ ШАЛГАВ

Эхлэл 18:1-33; 19:1-26

Олон жил өнгөрсөн бөгөөд Лот Содом хотын яг дотор нь нүүн орж суурьшжээ. Абрахам Бурханы өөрт нь сонгож өгсөн газарт майханд амьдарсаар байв. Нэгэн өдөр гурван танихгүй хүн Абрахамын гэрт нэгэн мэдээтэй иржээ. Тэд эгэл жирийн айлчид биш ажээ. Хоёр нь тэнгэр элч байв. Гурав дахь нь Эзэн Өөрөө байжээ!

“Абрахам, чи Намайг дагасан. Чи гэрийнхнийгээ Намайг дагадаг байхаар удирдсан. Чи Бурханаар ивээгдсэн учир Би юу хийх гэж байгаагаа чамд

хэлнэ” гэж Эзэн хэлэв (Эхлэл 18:17-21). Бурхан Абрахамын итгэл ба дуулгавартай байдлыг хүндэлж, түүнд найзын ёсоор нууцаа шууд хэлжээ.

“Содом Гоморра хотууд нь маш бузар болсон тул Би тэднийг устгах болно” хэмээн Эзэн үргэлжлүүлэн хэлэв.

Абрахам, одоо хувиа хичээсэн Лот зохих зүйлээ хүртэх боллоо гэж бодож болох байв. Гэвч Абрахамыг айдас цочирдол нөмөрчээ. Лот болон түүний гэр бүл Содомд амьдардаг. Хэрэв Бурхан Содомыг устгавал тэд бас алагдах болно гэж тэр бодов.

Зураг №10



Абрахам “Өө, Эзэн, хэрэв Содомд 50 бурханлаг хүн байвал Та тэднийг бузар хүмүүстэй цуг устгах уу? Үгүй биз дээ?” гэж асуув.

“Үгүй, Абрахам, хэрэв Би тэндээс 50 бурханлаг хүн олбол Содомыг устгахгүй. Би тэдний төлөө бүхэл хотыг устгахгүй үлдээнэ” гэж Эзэн хариулав.

“Өө, Эзэн минь,” хэмээн Абрахам дахин гуйж, “хэрэв тэндээс 45 бурханлаг хүн олдвол та хотыг устгах уу?” гэж асуув.

“Үгүй, Абрахам, Би 45 бурханлаг хүний төлөө хотыг устгахгүй” гэж Эзэн амлав.

Абрахам Содомыг хэлтрүүлэн үлдээлгэхийн тулд Эзэнээс шалан гуйхаа үргэлжлүүлж байв. “Хэрэв тэнд 40, 30, 20, 10 зөвт хүн байвал яах вэ?” гэж асуув. Эзэн, тэр хотоос 10 бурханлаг хүн олдвол Би хотыг устгахгүй гэж амлав.

Абрахам, Лот болон түүний гэр бүлийн төлөө ийнхүү санаа зовж байжээ. Эзэн гуйлтад хариулна гэдгийг тэр мэднэ. Тиймээс тэр тэдний төлөө гуйжээ.

Гэвч Содом ба Гоморра хотод ядаж арван бурханлаг хүн байсангүй. Гэсэн хэдий ч Бурхан Абрахамын гуйлтуудыг сонсов. Тэр Абрахамын сэтгэлийг мэдэв. Абрахам ач дүү Лотынхоо төлөө хичнээн их санаа тавьж байгааг тэр мэдэв. Тиймээс хотыг устгахаар Бурханыг гал буулгахаас өмнө тэнгэр элчүүд Лот, түүний эхнэр болон хоёр охиныг Содомоос гаргажээ. (Эхлэл 19:15, 24, 25-ыг үз.)

“Хот руу бүү эргэж хар! Амийнхаа төлөө зугт!” гэж тэнгэр элчүүд тушаав. “Хэрэв та нар эргэж харвал үхэх болно!” (Эхлэл 19:17-г үз.)

Лотын эхнэр тэр хотод маш их хайртай байв. Тиймээс тэр тэсэлгүй эргэж харав. Тэр даруй тэр давсан хөшөө болжээ. Тэр яг тэнгэр элчүүдийн сэрэмжлүүлэн хэлсний дагуу үхэв! (Эхлэл 19:26-г үз.)

Лот хамгийн сайхан харагдсан газрыг, хялбар болон тухтай амьдарч болох газрыг сонгож авсан байв. Одоо тэр өөрт байсан бүхнээ алдав, хоёр охиноос бусдыг бүгдийг нь алдав. Хэрэв Лот хаана амьдрах ёстойгоо, юу хийх ёстойгоо Бурханаас асуусан байсан бол хамаагүй илүү дээр байх байлаа.

Абрахам өөрийнх нь төлөө Бурхан сонгохыг зөвшөөрчээ. Тэр Бурханыг хүндэтгэж байв. Тэр залбирлаараа дамжуулан Бурхантай хамт хүчирхэг байлаа. Тэр Бурханд итгэж, Бурхан түүний гуйлтуудад хариулав. Хэрэв Абрахам гуйгаагүй бол Лот бас алагдах байсан байж магад. Бурхан чиний гэр бүлийнхээ болон найз нарынхаа төлөө гуйх залбирлыг сонсох болно. (Иохан 14:13, 14-ийг үз.)

3. АБРАХАМЫН ХАЙРЫГ ШАЛГАВ

Эхлэл 22:1-14

Бурханд Абрахамыг сорих, урьд өмнөх бүх сорилтуудаас илүү хүнд нэг шалгуур байв. Бид өмнөх

хичээлээр Абрахам Сара хоёр бяцхан хүү Исаакийн мэндлэхийг хорин таван жил хүлээсэн тухай үзсэн. Тэр энэ гэр бүлийг ямар их аз жаргалтай болгосон бол! Түүний өсөхийг хараад тэд, Бурхан амласан олон үр хүүхдүүдээ Исаакар дамжуулж тэдэнд өгөх юм байна гэдгийг мэджээ.

Нэгэн шөнө Бурхан Абрахамд нэг хачин тушаал өгчээ. “Абрахам, чи хайртай хүү Исаакаа аваад Мориа гэдэг газар руу яв. Тэнд Миний чамд зааж өгөх уулан дээр тахилын ширээ өр. Тэгээд чи Исаакийг Надад тахил болгон өргө” гэв. “Исаакийг! Миний цорын ганц хүүг үү?” хэмээн Абрахам бодов. Хэрэв Исаак үхчихвэл би яаж Бурханы амласан тоолж баршгүй үр хүүхдүүдтэй болох билээ? Гэвч Бурхан алдаа гаргадаггүй. Тэр яагаад Исаакийг өргөл болго гэснийг би ойлгохгүй, гэвч би Түүний хэлснийг хийх болно. Хэрэв шаардлагатай бол Тэр амлалтаа сахин биелүүлэхийн тулд Исаакийг дахин амьдруулж чадна гэдгийг би мэднэ. (Еврей 11:17-19-ийг үз.)

Бурхан яагаад ийм хачин тушаал өгснийг Абрахам мэдэхгүй. Бурханы юу хийх гэж байгааг тэр мэдэхгүй байв. Харин Бурхан юу хийх гэж байгаагаа мэдэж байлаа. Тэр Абрахамыг Өөрт нь итгэж, Өөрийг нь дагахыг хүсч байв.

Абрахам “Өө, Бурхан минь, хэрэв би Исаакийг тахил болгон өргөчихвөл Та хэрхэн надад олон хүүхэд, ач үрсийг өгөхийгөө харуулаач. Тэгвэл би үүнийг хийе. Эхлээд надад харуулаач. Тэгээд би таныг дагая” гэж хэлж болох байсан.

Гэвч Абрахам өглөө эртлэн босч аян замд бэлтгэжээ. Энэ бол дагахад амар биш тушаал байлаа. Гэвч тэр үүнийг хойш тавьсангүй. Тэр шатаалт тахилд хэрэглэх мод авч илжгэнд ачив. Хоёр зарц түүнийг дагав. Эцгийнхээ, амьд Бурханд өргөдөг тахилд Исаак дассан байлаа. Энэ удаа тэр өөрөө тахил болно гэдгээ мэдээгүй байв. Аян замын гурав дахь өдөр Абрахамыг өмнөө байгаа уул руу харахад Бурхан “Абрахам, энэ бол чиний Исаакийг өргөх газар” гэж хэлэв.

Абрахам зарц нартаа “Исаак бид хоёрыг тахил өргөж байх үед та нар энд хүлээж бай. Бид буцаж ирнэ” гэж хэлэв. Абрахам хоёулаа буцаж ирнэ гэдэгт итгэж байв. Яаж гэдгийг тэр мэдэхгүй, гэвч Бурханд найджээ.

Илжигнээс модоо буулгаад тэр Исаакийн мөрөнд үүрүүлэв. Дээш өгсөж байхдаа Исаак аав руугаа эргэн “Аав аа, танд хутга, хэт цахиур нь байна. Мод нь надад байна. Бурханд өргөх тахилын хурга нь хаана байгаа юм бэ?” гэж асуув.

“Хүү минь, Бурхан бидэнд өргөлийг хангах болно” гэж Абрахам итгэлтэйгээр хэлэв.

Биднийг дээш гарахад уулын орой дээр хурга байж болох юм гэж Абрахам бодсон байж магад. Хэрэв үгүй бол би хайртай хүүдээ хэрхэн, чамайг өргөл болгон өргөнө гэж хэлэх билээ?

Уулан дээр тэд тахилын ширээ өрөв. Тэгээд Абрахам Бурхан юу гэж тушаасныг тайлбарлав.



Зураг №11

Исаак аавдаа хайртай, түүнд найддаг. Тэр түүнийг дуртайяа дагав. Тэр аавдаа өөрийг нь хүлэхийг зөвшөөрөв. Огтхон ч царгалалгүйгээр тахилын ширээн дээр хэвтэв.

Абрахам хутгаа авч хүүгээ алахаар далайлаа. Тэр агшинд Эзэн “Абрахам! Абрахам!” хэмээн дуудав.

“Би энд байна” хэмээн Абрахам хариулав.

“Хүүд бүү хүр! Чи Намайг үнэхээр хайрладаг гэдгээ Надад харууллаа. Чи Надаас өөрийн хамгийн эрхэм, цорын ганц хүүгээ харамлаагүй” гэж Эзэн хэлэв.

Абрахам эргэн тойрноо хартал нэгэн хуц бутанд эврээрээ орооцолдсон байх нь харагдав. Яг түүний Исаакт хэлсний дагуу Бурхан өргөлийн малыг хангажээ. Абрахам хуцыг Исаакийн оронд тахилын ширээн хурдан тавив. Абрахам зүрх сэтгэлдээ Төгс Хүчит Бурханд ямар их баярлаж талархсан бол!

“Абрахам, чи Надаас юугаа ч харамлахгүй байгааг Би харлаа. Би чамайг асар ихээр ерөөнө. Чи Надад дуулгавартай байсан учир Би чамар дамжуулж дэлхийн бүх үндэстнийг ерөөх болно. Чиний үр хүүхдүүд тэнгэрийн одод шиг, тэнгисийн эргийн элсний ширхэг шиг тоолохын аргагүй олон болно” хэмээн Бурхан айлджээ.

3. ШАЛГУУР БОЛ БУРХАНЫ ЗОРИЛГЫН НЭГ ХЭСЭГ ЮМ **1 Коринт 10:13**

Бурхан Абрахамд Өөрийгөө хэн гэдгийг, Өөрийнхөө ямар болохыг мэдүүлэхийг хүсчээ.

Тиймээс Бурхан Абрахамыг сорив. Шалгуур бүр нь Абрахамыг Бурханыг улам илүү таньж Түүнд улам илүү найдахад хүргэжээ.

Эхлээд Бурхан Абрахамд төрсөн нутгаа орхиж, Өөрийнх нь зааж өгөх газар луу нүү гэж тушаав. Абрахам итгэж, Бурхан Өөрийн Үгээ сахин биелүүлдэг гэдгийг сурчээ.

Дараа нь Бурхан Лот Абрахам хоёрыг салгав. Түүнд сонголт хийхийг зөвшөөрснөөрөө Абрахам Бурханы сонголт хамгийн сайн гэдгийг сурчээ.

Бурхан Абрахамд хүү өгнө гэж зургаан удаа амлажээ. Гэвч Бурхан Абрахамыг амлагдсан хүүг хүлээн автал хорин таван жил хүлээлгэжээ. Бурхан амлалтаа Өөрийнхөө цагт биелүүлдэг гэдгийг Абрахам сурчээ.

Эцсийн шалгуур нь хамгийн хүнд байв. Бурханы Өөрийнх нь өгсөн тушаал ойлгох боломжгүй хэцүү байсан ч Абрахамыг Өөрийг нь дагадаг байхад бэлтгэжээ.

Бурхан түүнтэй ярьж, Исаакийг хэлтрүүлэхэд Абрахам Бурханд урьд өмнөхөөсөө улам илүү итгэжээ.



Зураг №12

Бурхан Абрахамд цорын ганц хүү Исаакаа тахил болгон өргө гэж тушаажээ. Абрахам дуулгавартай дагав. Гэвч эцсийн агшинд Бурхан орлуулагч тахилыг хангаж өгөв.

Олон жилийн дараа Бурхан Өөрийн цорын ганц Хүүг өршөөн хэлтрүүлээгүй билээ.

(Ром 4-ийг үз.) Эзэн Есүс туулах ёстой бүх замыг туулж, загалмай дээр бидний нүглүүдийн төлөө төгс өргөл болон үхсэн билээ. Бурхан, Абрахам Исаакийг хайрладгаас хамаагүй илүүгээр Өөрийн Хүү Эзэн Есүс Христийг хайрладаг байсан. Тийм ээ, Бурхан Өөрийн Хүүг бидний төлөө үхүүлэхээр илгээх хүртлээ хангалттай хайрлажээ. Тэр хичнээн их хайрладаг ч гэсэн Есүсийг гэмийнх нь төлөө үхсэн гэдэгт итгэхээс татгалздаг хэнийг ч Мөнхийн Улсад хүлээн авч чадахгүй. Хүн зөвхөн Эзэн Есүст хамааралтай байж Тэнгэр Улсад хүрнэ гэдэгт чи итгэдэг үү? Эсвэл өөр зам байдаг гэдэгт итгэдэг үү? (Иохан 14:6-г үз.)

Хичээл №4 ШАГНАГДСАН ИТГЭЛ

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Хүн бүр хэрхэн амьдарч байснаа Эзэнд тайлагнах ёстой бөгөөд Христчин бүрээр хийлгэх ажил Бурханд байдаг гэдгийг ойлгоход нь оюутан бүрд тусал. Өөрсдийн амьдралын төлөөх Бурханы төлөвлөгөөг мэдэж, түүнийг гүйцэтгэхээс илүү шагнал гэж байхгүй. Оюутнуудаа Бурханы төлөө амьдарч, Түүнд үйлчлэхийн төлөө уриал.

Сбәәәб Аеәеәеи еөеүе;ä: Эхлэл 15; Ром 3, 4; хичээлд дурьдагдсан бүх ишлэлүүд.

Өе-үүеәеи сiддәәй: Бурханд итгэж, Түүнд захирагдсаны төлөө одоо ба ирээдүйн аль алинд нь ирэх шагналыг харуулах.

Ἰρῶδιόβαῦι ἰυῖυδ , ἡδιε с;еә: Зөвхөн Христчин амьдрал л үнэ цэнэтэй амьдрал юм.

Ἰρῶδιόβαῦι ἰυῖυδ , ἡδιε с;еә: Бурханы Үгэнд тушаасны дагуу амьдрах хүсэл.

Ἰρῶδιόβαῦι дддд ёстой с;еә: Бурханы тушаалуудыг дагаж амьдрахаа тодорхойлох.

Өе-үүеәеи д°е°әе°а°° (аааә, Ἰρῶδιό дүiаүәеүл):

1. Бурханы бэлэг: Зөвтгөл (Ром 4:19-25; 15:6).
2. Итгэлийн шагнал: Бурхантай нөхөрлөх (1 Иохан 1:3; 5:14-15; Иаков 2:23; Марк 9:41; 1 Тесалоник 4:16-17).
3. Итгэмжтэй байдлын төлөө Бурханаас ирэх ерөөлүүд (Иохан 14:27; Ром 8:35-39).
4. Итгэгч хүний гэрчлэл (Эхлэл 23).

Öүүәеүд еөеүе:

Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан руу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. (Еврей 11:6)

ХИЧЭЭЛ

Бэлэг шагнал хоёрын ялгаа юу вэ? (Ярилцахыг дэмж.) Чи бэлэг аваад үнийг нь төлдөг үү? (Үгүй.) Чи шагнал авахын тулд яах ёстой вэ? (Үүнийг авахын тулд ямар нэг юм хийдэг.)

Итгэлийн тухай энэ сүүлчийн хичээлээр бид хамгийн чухал бэлэг болон шагналын тухай ярилцана.

1. БУРХАНЫ БЭЛЭГ: ЗӨВТГӨЛ Ром 4:19-25; 15:6

Бурхан Абрахамыг дуудаж, Урыг орхин яв гэж тушаасан нь Абрахам Урд амьдардаг бусад хүмүүсээс илүү сайн байснаас болсон юм биш.

Бурхан Абрахамыг сайн хүн учраас түүнд хүү өгч, түүнийг олон үндэстний эцэг болгоно гэж амласан юм биш.


Абрахам бусад бүх хүний адил нүгэлтэн. Гэвч Абрахам Бурхан амласнаа биелүүлнэ гэдэгт итгэсэн юм. Тиймээс тэр нутгаа орхиж, Бурханы удирдлагыг дагажээ. (Ром 4:3-ыг хар.)

Абрахам Бурхан түүнд хэдийд, яаж хүү өгөхийг мэдэхгүй байв. Тэр Сара болон өөрийгөө хүүхэдтэй болоход дэндүү хөгширсөн гэдгээ л мэдэж байв.

Гэвч Бурхан амласан. Тэгээд боломжгүй зүйлийг Бурхан хийж чадна гэдэгт Абрахам итгэжээ. (Ром 4:19-22-ыг үз.)

Энэ нь Бурхан Абрахамд “Чи зүрх сэтгэлдээ Надад итгэсэн учир Би чамайг Өөрийнхөө гэр бүлд хүлээн авна. Чи бусад бүх хүмүүсийн адил нүгэлтэн болж төрсөн” гэж хэлсэн гэсэн үг юм. (Ром 3:23-ыг

үз.) Гэвч Би чиний нүглүүдийг уучилж байна. Учир нь чи хэдийгээр энэ нь яаж болохыг ойлгоогүй ч гэсэн Намайг чамд хүү өгнө гэж хэлэхэд чи Надад найдсан билээ.



Сбдддә '13

“Абрахам, чи Надад бүрэн итгэсэн учир Би чамд мөнх амийг өгнө. Чи үхээд Надтай хамт амьдрахаар Тэнгэр Улс руу ирэх болно.”

Абрахам Эзэнд итгэсэн бөгөөд тэр зөвтгөгдөж, зөвт хэмээн тунхаглагдав гэсэн нь ийм утгатай билээ. (Эхлэл 15:6-ыг үз.) Бурхан

Абрахамыг Өөртэй нь хамт зөв байр сууринд байгаагаар тооцжээ. Яагаад? Учир нь Абрахам Бурханд итгэжээ.

Бид төрөхдөө бүгд зөвт бус (гэмтэй) байдаг. (Ром 3:10, 12-ыг үз.) Бид хэрхэн зөвтгөгдөх (Бурхантай эвлэрсэн хэмээн тунхаглагдах) вэ? Бид хэрхэн Бурханы гэр бүлд хүлээн авагдаж, мөнх амийг авах вэ? Бид хэзээ ч сайныг үйлдсэнээрээ өршөөлийг хүлээн авч чадахгүй, учир нь бид хангалттай сайн байж чадахгүй. (Исаиа 64:6-г үз.)

Мөнх амь бол гайхамшигтай бэлэг юм. Энэ нь төлөгдөх боломжгүй юм. (Ром 6:23б-г үз.) Бид Бурханы хэлсэн нь үнэн гэдэгт зүрхэндээ итгэх ёстой. Тэр, Эзэн Есүс бол Миний Хүү гэж хэлдэг. (Матай 3:17; 17:5-ыг үз. 1 Иохан 4:14-15-ыг харьцуул.) Бид Эзэн Есүс бидний төлөө үхсэн гэдэгт итгэж, Түүнийг Аврагчаар хүлээн авах ёстой. (1 Коринт 15:34; Иохан 1:12-ыг үз.) Биднийг бүх найдвараа Эзэн Есүст тавихад Бурхан бидэнд мөнх амийг өгдөг. Өөрийн Хүү Эзэн Есүс Христээр дамжуулж, Бурхан биднийг зөвт гэж тунхагладаг. (Ром 4:24-25; Исаиа 61:10-ыг үз.) Бурхан Өөрийн авралын үнэгүй бэлгийг чамд өгөхийг хүсч байгаа. Чи өөрийн бүх найдварыг Түүнд тавьснаар энэ бэлгийг авах болно. Чиний итгэл Эзэн Есүс Христэд байна уу?

2. ИТГЭЛИЙН ШАГНАЛ: БУРХАНТАЙ НӨХӨРЛӨХ

1 Иохан 1:3; 5:14-15; Иаков 2:23; Марк 9:41;
1 Тесалоник 4:16-17

Биднийг аврагдсаны дараа Бурхан, итгэлээрээ Өөрийг нь хичээнгүйлэн дагаж яваа хүмүүст шагнал өгдөг. (Цээжлэх ишлэлийг хар: Еврей 11:6.) Христчин амьдрал бол удирдамж, хангамж болон бүх зүйлийн төлөө Бурхан руу харах итгэлийн тууштай амьдрал юм.

Сбдддә '14

Бурхан биднийг Өөртэй нь найз нөхөд байгаасай гэж хүсдэг. Үүнийг бид наад зах нь дөрвөн аргаар хийж болно:

А. Бурханы Үгээр дамжуулж

Абрахамд Библи байгаагүй, учир нь Библи бичигдээгүй байв. Гэвч Бурхан Өөрөө түүнтэй үе үе ярьж, түүнд амлалт тушаалуудыг өгдөг байв. Төгс Хүчит Бурханы дуу хоолойг сонсоно гэдэг ямар нэр төртэй хэрэг вэ! Энэ бол итгэлтэй байдал болон дуулгавартай байдлаас нь болж Бурханы Абрахамд өгсөн шагналуудын нэг нь юм.



Абрахамыг нэг тушаалыг дагаж байхад Бурхан дахиад өөр нэгийг өгнө. Тэр заримдаа удаан хугацаагаар Бурханы дуу хоолойг сонсохгүй байх үедээ дуулгаваргүй болж байв. (*Багш*: Абрахамыг Египетэд байх үед Бурхан үзэгдсэн тухай ишлэл байдаггүй; мөн Ишмаэлыг төрснөөс хойш Исаакийн тухай шинэчилсэн амлалт өгөх хүртэлх хугацаанд Бурхан үзэгдсэн тухай ишлэл байхгүй.)

Хожим нь Бурханы Үг хуйлмал номонд бичигджээ. (Зураг дээрхи хуйлмал номыг харж байна уу?) Өнөөдөр бидэнд Библи хэмээх номонд Түүний Үг байна. Бурхан Үгээрээ дамжуулж бидэнтэй ярьдаг. Тэр Өөрийн тушаалуудаа бидэнд өгдөг. Тэр бидэнд амлалтуудыг өгдөг. Тэр бидэнд заахын тулд мөн Түүний Үгийг ойлгоход бидэнд туслахын тулд Ариун Сүнсээ бидний зүрх сэтгэлд өгдөг. Библи уншиж, Бурханы бидэнтэй ярихыг сонсоно гэдэг ямар онцгой эрх вэ! Чи өнөөдөр Библиэ уншсан уу? Чи өнөөдөр Бурханыг Өөртэйгээ яриач хэмээн гуйсан уу? Чи Бурханаас ирэх энэ амлалтыг өөрийн болгож хүлээн авсан уу?

Б. Залбирлаар дамжуулж

Абрахам Бурханы дуу хоолойг сонсоод тахилын ширээ өрж Түүний удирдамж ба тусламжинд талархаж байв. Тэр Түүнд амлалтаа сахин биелүүлсэнд нь талархав.

Чи болон би Бурханд Эзэн Есүсийн нэрээр залбирч болно. Энэ тухай бод! Бурхан биднийг Өөртэй нь яриасай гэж хүсдэг. (*Багш*: Залбирч буй хүний зургийг харуул.) Энэ бол Түүний гэр бүл дэх шагналуудын нэг юм. Бид үнэндээ ертөнцийн Бүтээгчтэй ярьж чадна шүү дээ! (1 Иохан 1:3-ыг үз.)

Бид хэн нэг хүнд, эсвэл юманд залбирах шаардлагагүй, мөн хэн нэг хүнийг өөрсдийнхөө төлөө Бурханд залбируулах тухай бодох, гуйх хэрэггүй юм. “Бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олж, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд зоригтойгоор ойртон очих ёстой” (Еврей 4:16).

Абрахам залбирлаар дамжуулж Бурхантай хамт хүчирхэг байв. Бурхан Содомыг галаар устгахаас өмнө Абрахамын залбирал гуйлтуудаар дамжин Лот ба түүний хоёр охин аврагджээ.

Бид ч бас Хүү Есүс Христийн нэрээр залбирвал Бурхантай хамт хүчирхэг байна. (Иохан 14:13-14; 1 Иохан 5:14-15-ыг үз.)

В. Зочломтгой байдлаар дамжуулж

Гурван тэнгэрлэг зочин Абрахамын майханд ирэхэд Абрахам тэдэнд “Тавтай морил. Жаахан амарцгаа. Би та нарын хөлийг угаая. Түр саатаж надтай хамт хооллоно уу?” гэж хэлэв. Абрахам Бурханы найз учир түүний зочломтгой байдлыг тэд хүлээж авахдаа баяртай байв. (Эхлэл 18:1-8; Иаков 2:23-ыг үз.) Бурхан биднийг бусад зочломтгой бай хэмээн тушаадаг. (1 Петр 4:9-ийг үз; Еврей 13:2-ыг харьцуул.) Хэрэв бид үүнийг Түүний нэрээр хийвэл Тэр биднийг шагнана хэмээн амладаг. Эзэнийг хайрладаг, Түүнд үйлчилдэг хүмүүст тусалж байгаа бол бид Түүнд тусалж байгаа хэрэг. (Матай 25:40-ийг үз.) Энэ бол Түүнд найдвараа тавьдаг хүмүүст өгөгддөг Бурханы бас нэг шагнал юм.

Г. Эш үзүүлэгээр дамжуулж

(Чи эш үзүүлэгчийн номлохыг харсан уу?)

Бурхан Абрахамыг болон түүнийг Өөрт нь итгэдгийг мэддэг учир Тэр түүнд Өөрийн нууцуудыг хэлжээ. Хүхэр ба гал Содом, Гоморраг устгасан нь Абрахамд гайхах зүйл биш байв. Яагаад? Учир нь Бурхан түүнд хийх гэж байгаа зүйлээ хэлсэн байв.

Бурхан нэгэн өдөр дэлхийг устгана гэдгээ Өөрийн

эш үзүүлэгчдээр дамжуулж бидэнд хэлсэн билээ. Гэвч Түүний дотор байдаг хүмүүс устгагдахгүй гэж Тэр хэлжээ. Эзэн яг Содом, Гоморраг устгахаас өмнө Лотыг хотоос гаргасан шиг дэлхийг устгахаас өмнө Эзэн Есүс итгэгчдийг авна. Үүнийг ойлгоход Ариун Сүнс хүмүүст тусална. (1 Тесалоник 4:16-17-г үз.)

3. ИТГЭМЖТЭЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БУРХАНААС ИРЭХ ЕРӨӨЛҮҮД

Иохан 14:27; Ром 8:35-39

Бурхан Абрахамыг маш баян болгожээ. Тэр олон мал сүрэгтэй, олон зарц нартай бас алттай байв. Гэвч эдгээр нь Абрахамын чухал хэмээн тооцдог зүйлүүд биш байв.

Абрахам Тэнгэр дэх орон гэрийг харж байв. (Еврей 11:10-ыг үз.) Түүний эзэмшсэн бүхэн түүнд Тэнгэр Улсад очиход тусалж чадахгүй гэдгийг Абрахам мэддэг байв. Тэр үхэхдээ энэ бүх өмч хөрөнгөө аваад явахгүй гэдгээ мэдэж байв. Тэр хэзээ ч мөхөхгүй зүйлүүдээр Бурханаар ерөөгдөх сонирхолтой байв.

Бурхан Абрахамд өгсөн амлалт бүрээ биелүүлэв. Абрахам агуу үндэстний эцэг болсон бөгөөд энэ нь өнөөгийн бидний мэддэг Иудей үндэстэн буюу Израиль юм. Энэ үндэстнээр дамжуулж Бурхан бидэнд Өөрийн Үг Библийг өгсөн билээ. (Ром 3:2-ыг үз.) Библиэр дамжуулж Бурхан бидэнд Өөрийгөө илчлэв. Дэлхийн бусад үндэстнүүд Түүний Үгийг уншсанаар ерөөгддөг билээ.

БАГШИД ХЭЛЭХ ТАЙЛБАР

Энэ хэсэгт гарах үрудам гэдэг үгийг тайлбарлахдаа зураг дээрхи олон хүмүүсийг харуул. Абрахам Мариа хоёрын хооронд маш олон хүн байсан гэдгийг дурьд: Исаак, Иаков, Давид Хаан, Соломон Хаан гэх мэт. Зураг дээрхи хаан болон бусад үр удмууд болох олон хүмүүсийг харж байна уу? Анхааралтай сонс.

Зураг №15



Бурхан Өөрийн Хүү Эзэн Есүс Христийн эх байлгахаар Мариа гэдэг залуу Иудей эмэгтэйд сонгожээ. Мариа Абрахамын үр удам байв. (Матай 1:16-17-г үз.)

Ийнхүү Бурхан “Чиний үрсээр дамжуулж бүх үндэстэн ерөөгдөх болно” гэж Абрахамд хэлсэн амлалтаа биелүүлжээ (Эхлэл 12:3; 22:18). Бүх дэлхий дээр Христийг

Аврагч хэмээн найдсан хүмүүс Абрахамын энэ үр удмаар ерөөгддөг.

Бурхан хүн бүрийг эд баялгаар ерөөгөөд байдаггүй. Гэвч Өөрийнх нь гэр бүлд дахин төрсөн хүн бүрийг ерөөдөг. Түүний гэр бүлийн хүмүүс: Зүрх сэтгэлээрээ амар тайван байдаг (Иохан 14:27). Баяр хөөртэй байдаг (Иохан 15:11). Түүний хайр дотор байдаг (Ром 8:35-39).

Бурхан биднийг Өөрийнх нь бидэнд бэлдэж байгаа тэнгэрлэг хот руу харж амьдрахыг хүсдэг. (Колоссай 3:1-2-ыг үз.) Тэр биднийг Өөрийнх нь хэзээ ч алга болохгүй ивээлийг сонирхохыг хүсдэг.

4. ИТГЭГЧ ХҮНИЙ ГЭРЧЛЭЛ

Эхлэл 23

Абрахамыг таньдаг бүхэн түүнийг харж байв. Тэд түүнийг өөрийн шүтдэг амьд үнэн Бурханы тухай ярьж байхыг сонсчээ. Тэд Тэнгэрийн амьд Бурхан хүчирхэг бөгөөд түүний залбирлуудад хариулдаг гэдгийг түүний амьдралаас харжээ.



Зураг №16

Нэгэн өдөр нэг хаан Абрахам дээр ажил хэргээр ирээд түүнд “Таны хийсэн бүхэнтэй Бурхан хамт байна” гэж хэлжээ (Эхлэл 21:22).

Сараг үхэхэд Абрахам хөршийндөө нэгэн хүсэлтэй очиж “Эхнэр минь нас барав. Энэ улсад надад өөрийн гэсэн ямар ч газар байхгүй. Би эхнэрээ оршуулах газар худалдан авмаар байна. Надад хэсэг газрыг худалдана уу?” гэжээ.

“Абрахам, та бол бидний дундах агуу ноён. Та Сарагаа оршуулахыг хүссэн ямар ч газрыг сонгон авч болно” гэж тэд хариулав.

Бурханыг мэддэггүй тэдгээр хүмүүсийн өмнө Абрахам ямар сайн гэрчлэлтэй байна вэ! Бурхан Абрахамыг Өөрт нь итгэж, найддаг учраас түүнийг шагнажээ. Бурхан Өөрийг нь хүндэлдэг Абрахамд

бусадтай найрсаг амьдрах чадварыг өгчээ.

Чиний хөршүүд болон найзууд чиний тухай юу гэж ярих вэ? Бурхан Өөрийн хүүхдүүддээ тэдний дотор амьдрах Ариун Сүнсийг өгдөг. Ариун Сүнс итгэгчдэд Бурханыг хайрладаг гэдгээ бусдад мэдүүлж амьдрах чадварыг өгдөг.



Зураг №14

Чи өдөр бүр Бурханы Үгийг уншдаг уу? Чи өдөр бүр Бурхантай ярих цаг гаргадаг уу? Чи бусдын төлөө сайн үйл хийж тэдэнтэй найрсаг байдаг уу? Чи бусдыг гэртээ зочилдог уу? Бурханы, эш үзүүлэгчдээрээ дамжуулан ирээдүйн тухай илчилсэн нууцуудыг чи мэддэг үү?

Бурханы шагналыг хүртэх эелдэг найрсаг Христчин хүн байхын тулд юу хийх ёстойг дэвтэртээ жагсаан бич. Тэгээд өнөөдрөөс эхлээд эдгээр зүйлүүдийг хийхэд туслаач гэж Бурханаас гуй.